ТӨВ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТ /2016-2024 ОН/

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2016 оноор/	Зорилтод хүрэх түвшин, үр дүн		Хугацаа /оноор/	Хэрэгжүүлэх байгууллага
				I үе шат 2020 он	II үе шат 2024 он		
1	Цагдаагийн газрын жишиг ажлын байртай болсон байна. /Албаны сургалт, тусгай бэлтгэлийн сургалт явуулах сургалтын кабинеттай болох/	Цагдаагийн газрын одоогийн барилга нь албан ажлын зориулалтын бус хэвлэх үйлдвэрийн барилга байсан ба 1998 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засварлаж орсон. Одоогийн байдлаар ажлын байранд нийт 80 алба хаагч ажиллаж байгаагаас өрөө, тасалгааны хүрэлцээ муу, ЭБША, гэрч хохирогчийг байцаах уулзах өрөө дутагдалтай, алба хаагчдыг сургаж дадлагажуулах танхим, бие бялдрын болон албаны тусгай бэлтгэлийн өрөө зайлшгүй шаардлагатай.	3,6 тэрбум	Барилгын ажил эхэлсэн байна.	Барилгын ажил дуусч үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.	1 жил	Аймгийн ЗДТГ, ЦГ
2	Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Сэргэлэн сумын Хөшигийн хөндийд стандартын шаардлага хангасан Цагдаагийн байртай болно.	Нисэх онгоцны буудал ашиглалтанд орж байгаатай холбогдуулан цагдаагийн хэлтэс /тасаг/ шинээр байгуулан ажиллуулахаар шийдвэр гарч байгаа тул алба хаагчдын ажиллах байр шинээр бий болгох шаардлага тулгарч байна.	1,0 тэрбум	Барилга ашиглалтанд орсон байна.	-	6 сар	Аймгийн ЗДТГ, ЦГ
3	Дундговийн чиглэлийн хатуу хучилттай замд замын цагдаагийн хяналтын пост барих	Хяналт шалгалт сайжирч зам тээврийн осол, хэрэг буурна.	100,0 сая төгрөг	Замын цагдаагийн хяналтын пост баригдаж ашиглалтанд орж үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.	-	3 сар	Аймгийн ЗДТГ, ЦГ
4	Улсын чанартай авто замуудыг камержуулах, хяналтанд авах, Цагдаагийн газартай холбож давхар хяналттай болгох /Баянчандмань, Эрдэнэ, Баян, Эрдэнэсант, Лүн, Жаргалант, Борнуур, Дундговийн чиглэлийн хатуу хучилттай замуудад/	Хяналт шалгалт сайжирч зам тээврийн осол, хэрэг буурна.	840,0 сая төгрөг	Камерын системд бүрэн холбогдсон байна.	-	1 жил	Аймгийн ЗДТГ, ЦГ
5	Цагдаагийн газрын эзэмшлийн дэд бүтэцтэй газруудад орон сууц барих	Цагдаагийн газрын алба хаагчдын 80 орчим хувь нь 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг ба ихэвчлэн түрээсийн байр, ЦГ-ын албан конторын зориулалтаар ашиглаж байсан хуучин байранд амьдарч өөрийн орон сууцгүй байгаа тул залуу гэр бүлийг дэмжих, орон сууцжуулах зорилгоор ЦГ-ын хуучин конторын байр, 7-н айлын орон сууцыг буулган суурин дээр нь /зах зээлийн үнээс бага өртөгтэй/ 25 айлын 2 орон сууц барьж алба хаагчдыг хөнгөлттэй зээлд хамруулах ажлыг зохион байгуулна.	1,6 тэрбум	Алба хаагчдын нийгмийн баталгаа хангагдана. ЦГ-ын залуу гэр бүлийн 30 хувь нь шинэ байран орсон байна.	Алба хаагчдын нийгмийн баталгаа хангагдана. ЦГ-ын залуу гэр бүлийн 30 хувь нь шинэ байран орсон байна	2 жил	Цагдааги йн газар
6	Авто машины парк шинэчлэлт хийх, сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах, дунд оврын туулах чадвар сайтай суудлын авто машинаар хангах	Албаны бэлэн байдал хангагдаж иргэдэд түргэн шуурхай үйлчилнэ.	600,0 сая төгрөг	ЦГ-ын болон сумдын 50 хувь нь авто машинтай болсон байна.	Авто машины парк шинэчлэл бүрэн хийгдсэн байна.	2 жил	Аймгийн ЗДТГ, ЦГ
7	Сумдын хэсгийн төлөөлөгчдийн байрыг шилэн кабельд холбох	Гэмт хэрэг, зөрчлийн санд гомдол мэдээллийг хугацаанд нь шивж оруулах, сантай ажиллах боломжтой болж, цахим хэлбэрээр мэдээллийг солилцоно.		Бүрэн хэрэгжсэн байна.	-	5 жил	Аймгийн ЗДТГ, ЦГ
8	Алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж компьютер, техник хэрэгслээр хангах /Бие бүрэлдэхүүний 50%-ийг/	Ажлын бүтээмж дээшилж техник технологийн ашиглалт нэмэгдэж иргэдэд хүргэх үйлчилгээ сайжрана.	250,0 сая	Бүрэн хэрэгжсэн байна.	-	1 сар	Аймгийн ЗДТГ, ЦГ